

# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

№ 24/03

Улаанбаатар хот

## Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг болон Компанийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 8 (Найман) төгрөгөөр тогтоож, 2023 оны цэвэр ашгийн 29.9 (Хорин ес аравны есөн) хувийг буюу 5,914,413,464 (Таван тэрбум есөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун арван гурван мянга дөрвөн зуун жаран дөрвөн) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

